



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 1/67

Улаанбаатар хот

Г Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар дөрөв” ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны A/614 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдж, эзэмшигч байгууллагад нь сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн 12,200,000 (арван хоёр сая хоёр зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай HD-120 маркийн 05-18 УНП улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар дөрөв” ОНӨААТҮГ (П.Дэлгэрдалай)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 1,000,000 (нэг сая) төгрөгөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд орлого болгон авахыг Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар дөрөв” ОНӨААТҮГ (П.Дэлгэрдалай)-т үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар дөрөв” ОНӨААТҮГ (П.Дэлгэрдалай)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус даалгасугай.

ДАРГА

М.БАЯРАА



115050000817

C:\Users\Umch\Desktop\TX\Бланк\Тушаал.docx